

СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХҮРЭЭНД

Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистр, докторт суралцуулах арга хэмжээг 1997 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 1600 гаруй хүн энэхүү зээлд хамрагдсан байна.

Бакалаврын сургалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Дэлхийн шилдэг 100 их, дээд сургуулийн бакалаврын сургалтад Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр оюутан суралцуулах хөтөлбөрийг 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүнд зөвхөн сургалтын төлбөрийг зээл хэлбэрээр олгодог. Амьжиргааны зардал болон байрны төлбөр зэрэг бусад төлбөрийг суралцагч өөрөө хариуцна. Дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Times Higher Education World University Rankings” (THE) болон “Academic Ranking of World Universities” (ARWU) жагсаалтын эхний 100-д багтсан их сургуулийг дэлхийн шилдэг их сургуульд тооцно.

2015-2016 оны дэлхийн шилдэг их, дээд сургуульд оюутан суралцуулах сонгон шалгаруулалтын мэдээллийг <http://www.meds.gov.mn/top2015> холбоосоор үзэж танилцана уу.

Магистр, докторын сургалт:

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр өндөр хөгжилтэй орны их сургуульд магистр, докторт суралцуулах сонгон шалгаруулалтыг тус яам Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Журам шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны “Журам батлах тухай” 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн зохион байгуулдаг.

2015-2016 онд Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр өндөр хөгжилтэй орны их сургуульд магистр, докторт суралцуулах сонгон шалгаруулалтыг тус яам 2015 оны 1 дүгээр сард зарлаж, холбогдох журмын дагуу зохион байгуулсан.

Жич: Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцах сонгон шалгаруулалтад тэнцэж, суралцах эрх авсан бакалавр, магистр, докторын оюутнууд Сургалтын төрийн сантай зээлээр суралцах гэрээ байгуулдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.sts.meds.gov.mn/index.php/mn/> холбоосоор үзэж танилцана уу.